



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/234/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг
Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/169
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.АРИУНБАТ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	239,052,435.25	166,271,413.66
33	АВЛАГА	6,653,500.00	6,053,500.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	600,000.00	00.00
335	Бусад авлага	6,053,500.00	6,053,500.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,053,500.00	6,053,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	232,398,935.25	160,217,913.66
354	Хангамжийн материал	201,323,935.25	130,337,913.66
35420	Аж ахуйн материал	155,306,888.75	94,904,113.66
35440	Түлш, шатах тослох материал	3,602,746.50	00.00
35450	Барилгын засварын материал	633,100.00	1,902,600.00
35470	Бусад хангамжийн материал	41,781,200.00	33,531,200.00
35600	Мал амьтад	31,075,000.00	29,880,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,052,211,651.19	3,750,818,216.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,052,211,651.19	3,750,818,216.40
392	Биет хөрөнгө	2,757,381,717.71	3,313,156,276.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,468,609,077.00	2,840,961,787.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-84,881,538.36	-123,296,252.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	234,300,000.00	372,280,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-185,083,333.45	-160,191,333.17
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	445,923,862.00	299,020,280.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-273,120,242.99	-115,433,930.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	265,648,218.11	182,656,153.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-159,056,157.32	-60,735,604.29
39214	Бусад үндсэн хөрөнгө	76,726,604.00	96,748,895.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-31,684,771.28	-18,853,719.74
393	Биет бус хөрөнгө	294,829,933.48	437,661,940.24
39301	Програм хангамж	65,682,000.00	22,482,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-59,348,666.72	-22,482,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	301,757,400.00	453,574,900.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-13,260,799.80	-15,912,959.76
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,291,264,086.44	3,917,089,630.06
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,291,264,086.44	3,917,089,630.06
51	Засгийн газрын хувь оролцоо	3,291,264,086.44	3,917,089,630.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,352,461,521.65	1,352,461,521.65
51101	Өмч: - төрийн	1,352,461,521.65	1,352,461,521.65
512	Хуримтлагдсан үр дүн	-653,583,396.64	-22,198,460.12
51210	Өмнөх үеийн үр дүн	-653,583,396.64	-648,024,003.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	625,825,543.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,592,385,961.43	2,586,826,568.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,291,264,086.44	3,917,089,630.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,715,029,009.00	4,549,444,982.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	302,980,470.00	940,413,727.40
120	Нийтлэг татварын бус орлого	302,980,470.00	940,413,727.40



120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	292,020,470.00	933,648,727.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,583,660.00	22,583,479.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,627,000.00	760,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	260,809,810.00	910,305,248.40
120009	Бусад орлого	10,960,000.00	6,765,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,412,048,539.00	3,609,031,255.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	199,057,739.00	475,354,955.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	743,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	197,914,439.00	475,354,955.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	400,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,212,990,800.00	3,133,676,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,212,990,800.00	3,133,676,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,795,318,065.20	3,920,676,578.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,795,318,065.20	3,920,676,578.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,668,703,239.86	3,691,964,668.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,091,637,598.00	1,054,293,424.56
210101	Үндсэн цалин	701,659,900.00	665,086,724.56
210102	Нэмэгдэл	258,389,217.00	249,777,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,944,000.00	97,944,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,644,481.00	41,484,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,236,411.00	129,895,440.00
210201	Тэтгэврийн даатгал	105,024,411.00	90,241,240.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,553,000.00	9,913,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,442,400.00	7,930,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,110,600.00	1,982,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,106,000.00	19,827,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,042,152.86	225,910,919.91
210301	Гэрэл, цахилгаан	7,859,586.86	6,892,463.91
210302	Түлш, халаалт	192,795,200.00	212,419,700.00
210303	Цэвэр, бохир ус	6,387,366.00	6,598,756.00
2104	Хангамж, бараа материалын зардал	142,608,896.30	122,911,091.17
210401	Бичиг хэрэг	20,339,800.00	21,630,049.00
210402	Тээвэр, шатахуун	85,587,532.50	60,857,166.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,049,302.80	10,200,070.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200,000.00	533,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,432,261.00	7,537,884.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	22,152,621.66
2105	Нормативт зардал	00.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,154,500.00	75,857,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,000.00	00.00
210602	Тавилга	00.00	750,000.00
210604	Урсгал засвар	53,104,500.00	75,107,100.00
2107	Томилолт, зочны зардал	30,757,600.00	14,325,600.00
210702	Дотоод албан томилолт	30,757,600.00	14,325,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,025,400.00	38,028,405.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	34,187,480.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,400,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	1,615,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	493,500.00	192,000.00



210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	724,000.00	1,171,000.00
210807	Газрын төлбөр	786,900.00	785,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	990,240,681.70	2,029,742,687.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	822,328,002.00	1,840,463,564.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,672,450.00	31,057,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	160,240,229.70	158,222,023.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,614,825.34	228,711,910.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	105,284,826.00	85,315,798.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	10,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	98,911,426.00	45,138,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,373,400.00	30,177,798.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,329,999.34	143,396,112.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,329,999.34	143,396,112.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-80,289,056.20	628,768,403.65
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,340,500.00	2,942,860.03
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,340,500.00	2,942,860.03
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,340,500.00	-2,942,860.03
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-85,829,556.20	625,825,543.62

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,352,461,521.65	2,592,385,961.43	-567,953,840.44	3,376,893,642.64
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,352,461,521.65	2,592,385,961.43	-567,953,840.44	3,376,893,642.64
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-85,629,556.20	-85,629,556.20
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,352,461,521.65	2,592,385,961.43	-653,583,396.64	3,291,264,086.44
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,352,461,521.65	2,592,385,961.43	-653,583,396.64	3,291,264,086.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,559,392.90	5,559,392.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,352,461,521.65	2,592,385,961.43	-648,024,003.74	3,296,823,479.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-5,559,392.90	00.00	-5,559,392.90
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	625,825,543.62	625,825,543.62
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,352,461,521.65	2,586,826,568.53	-22,198,460.12	3,917,089,630.06



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,451,734,692.00	3,632,974,734.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,397,160.00	23,343,479.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,397,160.00	23,343,479.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,397,160.00	23,343,479.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,583,660.00	22,583,479.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,813,500.00	760,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,422,337,532.00	3,609,631,255.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	209,346,732.00	475,954,955.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	743,300.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	197,914,439.00	475,354,955.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,688,993.00	600,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,212,990,800.00	3,133,676,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,212,990,800.00	3,133,676,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,437,930,702.00	3,601,157,284.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,437,930,702.00	3,601,157,284.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,306,634,276.66	3,369,888,071.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,091,637,598.00	1,054,293,424.56
210101	Үндсэн цалин	701,659,900.00	665,086,724.56
210102	Нэмэгдэл	258,389,217.00	249,777,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,944,000.00	97,944,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,644,481.00	41,484,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,236,411.00	129,895,440.00
210201	Тэтгэврийн даатгал	105,024,411.00	90,241,240.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,553,000.00	9,913,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,442,400.00	7,930,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,110,600.00	1,982,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,106,000.00	19,827,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,042,152.86	225,910,919.91
210301	Гэрэл, цахилгаан	7,859,586.86	6,892,463.91
210302	Түлш, халаалт	192,795,200.00	212,419,700.00
210303	Цэвэр, бохир ус	6,387,366.00	6,598,756.00
2104	Хангамж, бараа материалын зардал	116,514,489.80	94,285,099.01
210401	Бичиг хэрэг	19,130,300.00	19,005,449.00
210402	Тээвэр, шатахуун	65,408,300.00	46,726,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,049,302.80	10,480,150.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,200,000.00	533,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,726,587.00	17,539,500.00
2105	Нормативт зардал	2,678,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,678,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,251,300.00	82,597,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,751,300.00	5,751,000.00
210602	Тавилга	00.00	750,000.00
210604	Урсгал засвар	48,500,000.00	76,096,400.00



2107	Томилолт, зочны зардал	30,757,600.00	14,325,600.00
210702	Дотоод албан томилолт	30,757,600.00	14,325,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,237,410.00	44,500,025.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	40,370,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,400,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	1,615,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	493,500.00	192,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,936,010.00	1,460,000.00
210807	Газрын төлбөр	786,900.00	785,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	647,279,315.00	1,723,080,163.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	630,712,915.00	1,688,227,974.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,566,400.00	34,852,189.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,296,425.34	231,269,212.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	109,366,426.00	87,873,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	10,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	98,911,426.00	45,138,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,455,000.00	32,735,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,929,999.34	143,396,112.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,929,999.34	143,396,112.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,803,990.00	31,817,450.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,803,990.00	31,817,450.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,803,990.00	31,817,450.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,803,990.00	31,817,450.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,803,990.00	31,817,450.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,803,990.00	-31,817,450.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,143,936,300.0	3,013,654,907.5	130,281,392.5	95.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,143,936,300.0	3,013,654,907.5	130,281,392.5	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,052,393,200.0	2,925,781,807.5	126,611,392.5	95.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,022,856,500.0	1,012,808,524.6	10,047,975.4	99.0



210101	Үндсэн цалин	675,134,700.0	665,086,724.6	10,047,975.4	98.5
210102	Нэмэгдэл	249,777,800.0	249,777,800.0	00.0	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,944,000.0	97,944,000.0	00.0	00.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,929,300.0	125,929,300.0	00.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	86,275,100.0	86,275,100.0	00.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,913,600.0	9,913,600.0	00.0	100.0
210203	ҮОМШ-ний даатгал	7,930,800.0	7,930,800.0	00.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,982,700.0	1,982,700.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	19,827,100.0	19,827,100.0	00.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	227,719,700.0	225,910,919.9	1,808,780.1	99.2
210301	Гэрэл, цахилгаан	7,100,000.0	6,892,463.9	207,536.1	97.1
210302	Түлш, халаалт	212,419,700.0	212,419,700.0	00.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	8,200,000.0	6,598,756.0	1,601,244.0	-19.5
2104	Хангамж, бараа материалын зардал	94,285,100.0	94,285,099.0	01.0	100.0
210401	Бичиг хэрэг	18,885,700.0	19,005,449.0	-119,749.0	100.6
210402	Тээвэр, шатахуун	46,726,700.0	46,726,700.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,600,000.0	10,480,150.0	119,850.0	98.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	533,200.0	533,300.0	-100.0	00.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,539,500.0	17,539,500.0	00.0	100.0
2105	Нормативт зардал	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	104,625,000.0	104,624,850.0	150.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,528,600.0	16,528,600.0	00.0	100.0
210602	Тавилга	12,000,000.0	11,999,850.0	150.0	100.0
210604	Урсгал засвар	76,096,400.0	76,096,400.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	15,000,000.0	14,325,600.0	674,400.0	95.5
210702	Дотоод албан томилолт	15,000,000.0	14,325,600.0	674,400.0	95.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,290,100.0	54,290,025.0	12,000,075.0	81.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,370,100.0	40,370,100.0	12,000,000.0	77.1
210803	Даатгалын үйлчилгээ	1,615,100.0	1,615,025.0	75.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	192,000.0	192,000.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.0	77,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,250,000.0	11,250,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	785,900.0	785,900.0	00.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,394,687,500.0	1,292,607,489.0	102,080,011.0	92.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,359,833,300.0	1,257,755,300.0	102,078,000.0	92.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,854,200.0	34,852,189.0	2,011.0	00.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,543,100.0	87,873,100.0	3,670,000.0	96.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,543,100.0	87,873,100.0	3,670,000.0	96.0



213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,670,000.0	10,000,000.0	3,670,000.0	-26.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,138,000.0	45,138,000.0	00.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,735,100.0	32,735,100.0	00.0	00.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,143,936,300.0	3,013,654,907.5	130,281,392.5	95.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,133,676,300.0	2,990,311,428.5	143,364,871.5	95.4
132001	Орон нутгийн төсвөөс	3,133,676,300.0	2,990,311,428.5	143,364,871.5	95.4
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,260,000.0	23,343,479.0	-13,083,479.0	227.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,500,000.0	22,583,479.0	-13,083,479.0	237.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	760,000.0	760,000.0	00.0	00.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	77.00	77.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	11.00	11.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	32.00	32.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	475,954,955.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,954,955.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,923,714.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,484,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,484,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,966,140.00
210201	Тэтгэврийн даатгал	3,966,140.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	430,472,674.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	430,472,674.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	31,241.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	475,954,955.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	475,954,955.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	475,354,955.00
131106	Төсвийн урамшуулал	600,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хэмнэлтийн бодлогын талаар авах арга хэмжээний талаар, цалин хөлсний тооцоотой холбоотой, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/221 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар нь Монгол улсын хууль тогтоомж, Засгын газрын шийдвэрийг хэрэгжүүлэх болон аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэгдсэн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм төрийн захиргааны байгууллагын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр төсөл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах үйл ажиллагааг эрхэлнэ. Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албад нь Тамгын газраас боловсруулж, Засаг даргын шийдвэрлэсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээн ажилладаг орон нутгийн төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр



санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2.795.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 41.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 33.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,779.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө, дансны өглөг данс үлдэгдэлгүй байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	6.7	6.1	-0.6
Бараа материал	232.4	160.2	-72.2
Биет хөрөнгө	2,757.4	3,313.2	555.8
Биет бус хөрөнгө	294.8	437.7	142.8
Нийт хөрөнгө	3,291.3	3,917.1	625.8
Засгийн газрын хувь оролцоо	3,291.3	3,917.1	625.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,291.3	3,917.1	625.8

Авлага дансны үлдэгдэл 6.1 сая төгрөг байгаа нь 2 жилийн насжилттай болсон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 160.2 сая төгрөг болж өмнөх оноос 72.2 сая төгрөгөөр буурсан, биет хөрөнгийн дүн 3,313.2 сая төгрөг болж 555.8 сая төгрөгөөр өссөн, биет бус хөрөнгө 437.7 сая төгрөг болж 142.8 сая төгрөгөөр өссөн байна. Биет бус хөрөнгийн дүн өсөхөд суудлын авто машин, нутгийн аваргууд сургуулийн эзэмшилд байсан газар эзэмших эрхийг шилжүүлэн авсан нь материаллагаар нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо данс 3,917.1 сая төгрөг болж өмнөх оноос 625.8 сая төгрөгөөр өссөн нь, тайлант үеийн үр дүн 625.8 сая төгрөг нөлөөлсөн байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 4,549.4 сая төгрөг нийт зардал 3,923.6 сая төгрөг тайлант үеийн үр дүн 625.8 сая төгрөг байна. Нийт орлогод орон нутгийн төсвийн санхүүжилт 475.3 сая төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлого 933.4 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалт, үнэ төлбөргүй хүлээж авсан орлого 917.0 сая төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант хугацааны үр дүн 625.8 сая төгрөгөөр нөлөөлж нийт цэвэр өмчийн дүн 3,922.6 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсвийн төслийг 1,187.5 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд 1,919.1 сая төгрөгөөр анх баталж, аймгийн Засаг даргын 2021 оны А/140 тушаалаар 113.0 сая төгрөгийн хасах зохицуулалт хийсэн, АИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 01 тогтоолоор 1,111.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,143.9 сая төгрөгийн төсөв эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 3,143.9 сая төгрөг батлагдсанаас орон нутгийн төсвийн санхүүжилт 3,119.9 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 23.3 сая төгрөг, туслах аж ахуйн орлого 0.7 сая төгрөг нийт 3,143.9 сая төгрөг төвлөрсөн байна.

Тайлант онд 3,013.6 сая төгрөгийн зарлага гаргаж 130.3 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гарган орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 475.9 сая төгрөг хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, орон нутгийн байгууллагад тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг аймгийн болон байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эргүүл хяналт хийх, өвчлөлтэй тэмцэхэд аймгийн шуурхай штабын шийдвэр хэрэгжүүлэх, халдвар хамгааллын хэрэгслээр орон нутгийн байгууллагууд, эрүүл мэндийн байгууллага, иргэдийг хангахад 271.2 сая төгрөгийг орон нутгийн нөөц болон бусад зардлаас зарцуулсан байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын тайлант хугацааны нийт төсөв 3 тэрбум гаруй төгрөгийн төсөвт, олон хөтөлбөр, арга хэмжээнд мөнгөн хөрөнгө зарцуулж баримт бүрдүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлдөг боловч нэг нягтлан бодогч ажиллаж ажилтны ажлын ачаалал их байгааг анхаарах шаардлагатай байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 130.3 сая төгрөгийн хэмнэлт гаргасан явдал байна. Үүнд: Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 10.1 сая төгрөг, НДШ-ээс 2.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой 1.8 сая төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал 3.4 сая төгрөг, томилолтын зардал 0.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 114.1 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.



3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ (Сар бүр)-г сард бүр өгсөн 271.2 сая төгрөгийн тусламжийн зардал, таван сая төгрөгөөс дээш нийт зарлагын 29.0 сая төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим хуулийн нийцлийн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг хянан үзлээ. Үүнд:

- Тогтоолын 1.4. заалттай нийцэхгүй 205.7 сая төгрөгийн төсвийн зарцуулалт хийсэн байна.
- Тогтоолын 1.6. заалттай нийцэхгүй 16.8 сая төгрөгийн төсвийн зарцуулсан
- Тогтоолын 1.2. заалттай нийцэхгүй Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 2 ажилтны орон тоонд ажилтан томилон ажиллуулсан байна.
- Тогтоолын 1.7. заалтыг хэрэгжүүлэх талаар: Мэдээллийн 6 газартай гэрээ байгуулж 16.0 сая төгрөг зарцуулсан байна. Төрийн байгууллагын цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл, шийдвэрээс бусад үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулахдаа төрийн байгууллагын мэдээллийн суваг, сайтыг ашиглах болон байгууллагын олон нийттэй харилцах мэргэжилтний чиг үүргийн оновчтой тогтоон төсвийн хөрөнгийн хэмнэлт гаргах нь зүйтэй.

Тайлант жилийн төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолоор баталсан “2022 оны төсвийн хуулийн хэрэгжилтийг хангах тухай” журмын 5 дугаар зүйл заасан чиглэлийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.

Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын дагуу Засаг даргын нөөц хөрөнгийг Орон нутгийн нөөц хөрөнгө дансанд 1,076.7 сая төгрөг төвлөрснийг дараах зориулалтаар зарцуулсан байна. Үүнд:

ДД	Журмын заалт	Мөнгөн дүн /сая төгрөг/
1.	2.1.1.Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;	947.5
2.	2.1.4.Байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх;	43.1
3.	2.1.5.энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ;	32.3
4.	2.1.6. шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг.	53.8
	Дүн	1,076.7



АИТХ-ын 2020 оны 05 дугаар тогтоолоор 287.1 сая төгрөгөөр анх баталж 2021 оны 01 дугаар тогтоолоор 759.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт батлагдсан төсөв 1,046.7 сая төгрөг байна.

Гүйцэтгэлээр 1.076,7 сая төгрөгийн санхүүжилт авч 1.076,7 сая төгрөг зарцуулсан нь *Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан* “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4.2. “Нөөц хөрөнгийг зарцуулах шийдвэр нь тухайн жилийн орон нутгийн төсөвт батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн нийт хэмжээнээс хэтрэхгүй байна” заалттай нийцэхгүй байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн томилгоо, чөлөөлөлт тайлант онд олон гарсан нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2. “мэргэшсэн, тогтвортой байх” зарчимд нийцэхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснийг аудитаар дахин хянахад хэрэгжилт 90 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын санхүүгийн бүх үйл ажиллагааг бүрэн хамраагүй, түүврийн хэмжээнд ажил гүйлгээг хянан үзэж санхүүгийн тайлагналын үнэн зөв эсэхэд дүгнэлт гаргасан тул бусад ажил гүйлгээ, үйл ажиллагааг гүйцэтгэлийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 231.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 205.7 сая төгрөгийн 1 албан шаардлага, 25.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Цалингийн нэмэгдэлтэй холбоотой 0.8 сая төгрөгийг төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Тогтоолын 1.4. “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” заалттай нийцэхгүй 205.7 сая төгрөгийн төсвийн зарцуулалт тул зөрчлийн таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар:

- 1.1. Илрүүлэлт:** ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2, 1.6 заалттай нийцэхгүй 16.8 сая төгрөгийн төсвийн зарцуулалт хийсэн нь байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолоор баталсан “2022 оны төсвийн хуулийн хэрэгжилтийг хангах тухай” арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах.

2. Авлагатай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт:** Санхүүгийн тайланд хувь хүнээс авах насжилттай 6.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.
- 2.2. Өгсөн зөвлөмж:** Авлагын тооцоог барагдуулж ажиллах.

3. Цалин хөлсний тооцоотой холбоотой асуудал

- 3.1. Илрүүлэлт:** Ажилтны цалин хөлснөөс хувь хүний утасны төлбөр 2.5 сая төгрөг суутган тооцсон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2. “Ажилтны



нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгал нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хассан цалин хөлсний дүнгийн 20 хувиас, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, эсхүл хэд хэдэн суутгал зэрэг хийх бол цалин хөлсний 50 хувиас хэтрэхгүй байна” Заалттай нийцэхгүй байна.

3.2. **Өгсөн зөвлөмж:** Ажилтны цалин хөлснөөс хуульд заагаагүй суутгал хийхгүй байх.

4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой

4.1. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээ (Сар бүр)-г сард бүр өгсөн 271.2 сая төгрөгийн тусламжийн зардал, таван сая төгрөгөөс дээш нийт зарлагын 29.0 сая төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”-д заасан мэдээллийг тухай бүр нэгдсэн системд мэдээлж байх

5. Батлагдсан орон тоотой холбоотой

5.1. Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны Б/45 тушаалаар баталсан “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн батлах тухай” орон тооноос 3 орон тоо хэмнэж ажиллаж байгаа боловч “Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймгийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга” гэсэн албан тушаалын орон тоонд ажилтан ажиллуулсан байна. Аймгийн Засаг дарга данснаас, аймгийн Засаг даргын захирамжаар төрийн тусгай албан хаагч Б.Отгонбаярыг Цэргийн штаб-д орон тоогүй байхад гэрээт ажилтнаар ажиллуулсан байна.

5.2. Өгсөн зөвлөмж: Батлагдсан бүтэц орон тоо, албан тушаалын дагуу ажилтныг томилон ажиллуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар	5	26.2			1	0.8			4	25.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар	2	505.9					1	205.7	1	300.2
	Нийт дүн	7	532.1			1	0.8	1	205.7	1	271.2